



# СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№243 /452/

2022.01.10

Цаг үе, үйл явдал

## НЭГТГЭЛИЙНХЭН ЦАСАНД БООГДСОН МАЛЧДАД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЖ БАЙНА



Цас их хэмжээгээр орсны улмаас өвөлжилт хүндэрсэн зарим аймаг, сумдад Зэвсэгт хүчний алба хаагчид дэмжлэг үзүүлсээр байна. Тухайлбал, Дорнод аймагт Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн томилгоот бүлгүүд цасанд боогдсон малчин айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлж байгаа бол Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Архуст сумдад Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн малын өвс, тэжээлийг тээвэрлэн хүргэх ажлыг мөн гүйцэтгэж байна.

Төв аймгийн Онцгой комиссоос тавьсан саналын дагуу тус нэгтгэлийн авто техникийн инженер, ахмад Н.Энхбатаар ахлуулсан цэргийн алба хаагчид 3 нэгж техниктэйгээр дээрх сумдад ажиллаж байгаа юм.

Тэд малын өвс, тэжээлийг тээвэрлэн хүргэхийн зэрэгцээ айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, цаасанд боогдсон зам, давааг онгойлгож, тээвэрчдэд тусламж үзүүлсээр байна. Цэргийнхний нийгмийн хариуцлагын хүрээнд гүйцэтгэж буй энэхүү ажилд орон нутгийн удирдлага, малчид талархлаа илэрхийлсээр байгаа юм. Хошууч Д.ДОЛГОРЖАВ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| -6   | -21  |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 36   | 22   |

### ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ  | ЗАРАХ |
|-------|-------|-------|
| USD   | 3.468 | 3.475 |
| EUR   | 3.706 | 3.730 |
| CNY   | 510   | 513   |
| RUB   | 48    | 48.80 |
| JPY   | 26.32 | 26.50 |
| KRW   | 2.81  | 2.83  |

### ЗУРХАЙ



## ХИЛЧИД ИРГЭДЭД УЧИРЧ БОЛОХ 1.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖЭЭ



2023 оны 1 дүгээр сарын 09-ны өдрийн байдлаар Увс, Өмнөговь аймга дахь хилийн цэргийн 0311, 0131 дүгээр ангийн хариуцсан хэсгээр хил дамнан мал хулгайлах, хуурмаглал бүхий баримт бичиг

ашиглах улсын хил зөрчсөн 2 хүнийг хилийн манаа илрүүлэн, саатуулж, хуулийн байгууллагад шилжүүлсэн. Баян-Өлгий, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгийн хил орчмын нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, хуш модны самар бэлтгэх зорилгоор улсын хилийн зурваст зөвшөөрөлгүй нэвтэрсэн 42 хүнийг илрүүлж, хуулийн дагуу шийдвэрлэсэн.

Дорноговь, Сүхбаатар, Дорнод, Увс аймгийн нутаг дэвсгэрээр байгалийн давагдашгүй хүчин хүчин зүйлийн улмаас болон бэлчээрээр улсын хилд тулсан 1321 тооны малыг хил дээр тогтоож, иргэдэд учирч болох 1.4 тэрбум төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлж, малыг орон нутгийн иргэдэд хүлээлгэн өгчээ.

Өнгөрсөн 2022 онд Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн хилийн авулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлснээр хилийн зөрчил 12.2, хил орчмын дэглэмийн зөрчил 12.7 хувиар буурсан.

Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээр байгалийн давагдашгүй хүчин хүчин зүйлийн улмаас болон бэлчээрээр улсын хилд тулсан 19944 тооны малыг хилд дээр тогтоож, иргэдэд учирч болох 13.8 тэрбум төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлсэн байна.

**МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО**

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эд малын гарлагатай  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
08.40-17.19  
**Барилдлага:**  
Арвидах  
**Шүтэн барилдлага:**  
Авахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олодох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглалвал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 669,047,777

Эдгэрсэн

Нийт: 640,382,139

Нас барсан

Нийт: 6,716,176

## “ТАЛЫН МОРЬТОН ДАЙЧИД” ҮЗЭСГЭЛЭНГ БУУХААС ӨМНӨ АМЖИЖ ҮЗЭЭРЭЙ



**ТАЛЫН МОРЬТОН ДАЙЧИД**  
ҮЗЭСГЭЛЭН

Үзэсгэлэнгийн үзмэрийг цувралаар толилуулж байна.

Монгол цэргийн музей, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хамтран зохион байгуулсан “Талын морьтон дайчид” үзэсгэлэнг 01 дүгээр сарын 30 хүртэл Монгол цэргийн музейд зохион байгуулж байна.

Тус үзэсгэлэн нь Чингис хааны хүндэтгэлийн хэсэг, Морьт цэргийн аяны хангалт, хувийн бэлтгэлийн нөөц болох зэр зэвсгийг түүхэн хөгжлийг илтгэх үзмэрүүд, монголчуудын аж ахуй соёл, морины тоног хэрэгсэл, орчин үеийн дижитал технологи гэсэн хэсгээс бүрдэнэ.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагддаг Монголын эзэнт гүрний үе буюу XIII-XIV зууны үед хамаарах цэрэг эрсийн агсамж хэрэглэлтэй холбогдох олдворыг үзэгчдэд анх удаа дэлгэн үзүүлж байгаагаараа онцлогтой юм.

Үзэсгэлэнгээр өгүүлж буй түүх, үзмэр эд өлгийн талаар үзэгчид гар утсаараа QR код уншуулж мэдээлэл авах, VR дижитал төхөөрөмжөөр бодит мэдрэмжийг мэдрэх боломжтой.

### Цуврал 1

Сэлэм /модон хуйтай/  
Монголын үе  
Төмөр, мод  
Сүхбаатар аймгийн Онгон сум  
2010 он  
ШУА-Археологийн хүрээлэнгийн сан хөмрөг

### Илд, сэлэм

Илд гэдэг нэр нь юмыг илт, үлт цохих гэдгээс үүджээ. Бас “Юлд” ч гэх нь бий. Одоо гол төлөв “Сэлэм” гэж нэрлэх болсон. Сэлэм гэдэг нь хамниган манжийн “селе” буюу төмөр, “ме” буюу юм гэсэн үгнээс үүдсэн “Төмөр юм”, “Төмөр зэвсэг” гэсэн үг.

Дундад эртний монгол цэргийн гол зэвсэг нум сум байсан бол удаахид нь сэлэм ордог байв. XIII-XIV зууны үед монгол цэргийн хэрэглэж байсан олон төрөл,

хийцийн илдний дотроос архелогийн шинжилгээ, судалгаагаар олдсон баттай баримт бүхий жинхэнэ монгол хийцийнх нь гэвээс:

- 60 см-ээс урт /барилулын уртыг тооцохгүйгээр /, шулуун, хоёр талдаа иртэй “Дам/дэм/илд”
- Хурц үзүүртэй, нэг талдаа иртэй “Хотгор илд”
- Нэг талдаа иртэй, өргөн мөртэй, гурван талтай, шулуун “Шөр илд” зэрэг илд байна.

Монголчууд илд, хутганыхаа ирийг тусгай технологиор боловсруулж давхар ир суулгадаг, тухайлбал ган болд, гянт, анзаан, албин зэрэг хатууруулагч бодисыг ирийг нь дагуулан давхарлаж ширээн хатаах юмуу заримдаа ердийн төмөрт хатуу болд зуулган давхар иртэй болгодог байжээ.

**МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙ**



Цахим шууданд

“АХЛАГЧИЙН АЛБА ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД...

ТАСАГ, АЛБА, БАТАЛЬОН ЗАНГИЛГАА СУРТАЛЧЛАХ АЯН ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний “Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2024”-ийн хүрээнд ҮБХИС-БХМСҮТ-ээс таван анги, салбарын 60 гаруй цэргийн алба хаагчдыг хамруулсан даргалах албан тушаалын “Тасгийн захирагчийн дамжаа”-г Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн материаллаг баазыг

түшиглэн зохион байгуулж эхэлжээ. Хөдөлгөөнт сургалтын удирдагчаар тэргүүн ахлагч М.Одбаяр, сургагч багшаар сургагч ахлагч Т.Батболд, Н.Төмөрсүх, П.Баярмагнай, туслах багшаар ахлах ахлагч А.Сугирдаш нар ажиллаж байгаа аж.

Хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Зэвсэгт хүчний 013 дугаар анги

сарын 06-ний өдөр “Цэвэр агаар-Эрүүл мэнд” сэдэвт цасны баярыг ангийн сургалтын төвд амжилттай зохион байгуулсан юм.



2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс тасаг, алба, батальон зангилгаа сурталчлах аяныг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж эхэллээ.

Цасны баяраар ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд цасны суугаа гар бөмбөг, хөгжөөнт цасан буухиа, гийр өргөлт, саадын зурвас, хээрийн байрлалд шилдэг отог барих, болон Монгол дээл хувцас шалгаруулах уралдааныг зарлаж манлайлагчдаа тодрууллаа.

Сугалааны дарааллаар ангийн захирагчийн орлогч дэд хурандаа Н.Батсүрэн даргатай Материал хэрэгслийн хангалтын алба, алба сурталчлах шилжин явах тугийг гардан авснаар аяныг эхлүүлж, 2023 оны 01 дүгээр

СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЛБА

Зарлал

ИННОВАЦЫН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ



Зэвсэгт Хүчинд зэвсэглэлийн чиглэлээр нэвтрүүлж болохуйц дэвшилтэт технологи, мэдлэгийг баялаг болгох, сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажилд инноваци нэвтрүүлэхийн тулд зэвсгийн мэргэжлийн офицер, ахлагч, сонсогч нарын дунд шилдэг бүтээл шалгаруулах уралдааныг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар зарлаж байна.

**Нэг. Уралдааны зорилго**  
Мэдлэгийг баялаг болгох хөдөлгөөн улс орон даяар өрнөж байгаатай уялдуулан Цэргийн Зэвсгийн хэлтсээс зэвсэглэлийг сайжруулах, хангалтыг дээшлүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинэ мэдлэг, хамт олны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдний шинэ санаа, мэдлэгийг нийтийн хүртээл болгож, Зэвсэгт Хүчинд нэвтрүүлэн ашиглах.

**Хоёр. Зохион байгуулалт**  
2.1 Уралдаанд хувь хүн болон баг оролцож болно.  
2.2 Оролцогч бүтээлийн танилцуулгыг Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбоонд “Уралдааны танилцуулга” нэртэйгээр Word, Power point программ дээр боловсруулан batbold.dash@gmail.com, tsegmid.lkhagvaa@gmail.com цахим

хаягаар ирүүлнэ.  
2.3 Инновацийн шилдэг бүтээл шалгаруулах гишүүдэд зэвсгийн мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүд байна.  
2.4.Зэвсэгт хүчний анги бүрийн болон ҮБХИС-ийн зэвсгийн алба, багш нараас тус бүр нэгээс доошгүй бүтээлийн танилцуулгыг ирүүлэх бөгөөд бүтээлийн тоог хязгаарлахгүй.

**Гурав.Шилдэг бүтээлд тавигдах шаардлага**  
Орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашигласан оновчтой шинэ санаа эсвэл биет бүтээл байх бөгөөд цаашид зэвсгийн мэргэжлийн чиглэлийн үйл ажиллагаанд хөдөлмөр хөнгөвчилсөн, зардал хэмнэсэн, сургалт бэлтгэлд дэвшил болохоор шинэлэг зүйл байх.

**Дөрөв. Уралдааны шалгаруулалт**  
Уралдааныг дараах хоёр үе шатаар дүгнэнэ.  
4.1. Нэгдүгээр шат: 2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрийг дуустал  
Энэ шатанд бүтээлийн танилцуулгыг цахим хаягаар хүлээн авч, Зэвсгийн мэргэжилтнүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүдийн хуралд

Зэвсэгт хүчний 015 ангийн захирагчийн орлогч ахлах инженер танилцуулна. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж онолын ба практик ач холбогдол, шинэ бүтээл болох бодит боломж зэргийг хэлэлцэж, олонхын саналаар эхний 10 байрын бүтээлийг хоёрдугаар шатны шалгаруултад оролцуулна.  
4.2. Хоёрдугаар шат: 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр. Шалгарсан бодит бүтээлийг гишүүд ил тод, шударга зарчмыг баримталж ил санал хураалтаар 1, 2, 3 дугаар байр эзлүүлнэ.


**Тав. Хамрах хүрээ**  
5.1.Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний харьяа анги, байгууллагуудын зэвсгийн мэргэжлийн алба хаагч, сонсогч, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадуудаас бүрдсэн баг болон хувь хүн.  
**Зургаа. Шагнал**  
6.1. Шилдэг бүтээл 1 дүгээр байр - Өргөмжлөл 1,000,000 төгрөг  
6.2. Шилдэг бүтээл 2 дугаар байр - Өргөмжлөл 600,000 төгрөг  
6.3. Шилдэг бүтээл 3 дугаар байр - Өргөмжлөл 400,000 төгрөг

ЗЭВСГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБОО

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №54

ЧА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА  
ЧА үсэг бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй их төлөв таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан хуулан бичиж, кириллээр хөрвүүлээрэй.  
Дармал, бичмэл тигээр:



ӨГҮҮЛЭМЖТЭЙ ОНЦЛОХ ЗУРАГ

Монгол төрийн түүхээр аялахад монгол цэргийн түүхийн зам мөр тэнд заавал дурайж байдаг. 2023 он гарсаар орчин цагийн Зэвсэгт хүчин түүхийн шинэ хүрдээ ийнхүү эхлүүлэв.

Дараах хоёр зурагт хоёр өгүүлэмж байна. Эхний зурагт бэлтгэл хурандаа Л.Батболд, О.Эрдэнэбаатар нар хүндэт харуулын жагсаалыг анхааралтай харан сууна. Нэгэн цагт удирдаж явсан төрийн хонжин энэ удаа үзэгчийн суудлаас дайчдынхаа жагсаалыг нүд, чих, амьсгаа тавьж, сэтгэл догдлон анхааралтай ажиглан суух нь зургийн хальснаа бууж.

Хоёр дахь зурагт дайчдад чин сэтгэлээсээ алга ташин угтаж баяр хүргэж байгаа ээж. Магад түүний хүү алхсан ч байж мэднэ, эсвэл монгол цэргийн хөвгүүддээ талархалтай хандаж явдаг мянга мянган ээжийн нэг байх. Зураг бүхэн өгүүлэмжтэй гэж ...

